GOBI

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026он 10сар 07өдөр Дугаар 37 Улаанбаатар хот

Барьцааны гэрээг дэмжин зөвшөөрөх тухай

Монгол Улсын Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг болон Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 6.2 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.7.15, 6.2.7.17 дахь заалтуудыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Таванбогд Констракшн Машинери ХХК-ийн Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (цаашид “ЕСБХБ” гэх)-тай 2026 оны 7-р сарын 8-ны өдөр байгуулсан 143,000,000,000 (нэг зуун дөчин гурван тэрбум) төгрөг хүртэлх дүн бүхий зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар Хавсралт 1-т заасан, ЕСБХБ-нд өмнө нь барьцаалуулсан эд хөрөнгийг ЕСБХБ болон түүний нэрлэн заасан этгээдэд нэмж барьцаалуулахтай холбоотойгоор 2026 оны 7-р сарын 8-ны өдөр Компанийн байгуулсан барьцааны гэрээнүүдийг үүгээр дэмжин зөвшөөрч, баталгаажуулсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан барьцааны гэрээнүүдийн нөхцөл, агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцож, Компанийг төлөөлж гарын үсэг зурж баталгаажуулсан Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Амарсайхан), Таван Богд Холдингс ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил) нарын үйлдлийг зөвшөөрөн баталгаажуулж, барьцаа хөрөнгө нэмэгдүүлэх шаардлагатай тохиолдолд өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, улмаар эдгээр гэрээтэй холбоотой мэдэгдэл, баталгаа, гэрчилгээ, маягт, хавсралт болон бусад баримт бичигт гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийх эрхийг дангаараа эсвэл хамтран хэрэгжүүлэх эрхийг олгосугай.
3. Энэхүү тогтоол нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 8-р сарын 28-ны өдрийн 29 дүгээр тогтоолын агуулгыг зөвтгөн гарч буйг дурдсугай.
4. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 ⁂ 2076357

Д.ГЭРЭЛМАА

Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХҮРЭЛБААТАР

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn

2026 он 10 сар 07 өдөр Дугаар 38 Улаанбаатар хот

Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Говь ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 6.2 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.7.15 дахь заалтыг тус тус удирдлага болгон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Говь ХК-ийн Таван Богд Холдингс ХХК болон түүний охин компаниудтай хамтран ХААН Банктай байгуулсан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ЗЭНГ24/39 тоот Зээлийн эрх нээх гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
   1.1. Таван Богд Холдингс ХХК нь 100%-ийн хувьцаа эзэмшдэг охин компани Таван Богд Тек ХХК болон Таван Богд Холдингс ХХК нь 100%-ийн хувьцаа эзэмшдэг охин компани Таван Богд Интернэйшнл ХХК-ийн 100% хувьцаа эзэмшдэг охин компани болох Кореа Ти Би Кэй ХХК-ийг Зээлийн эрх нээх гэрээнд хамтран зээлдэгчээр нэмэх.
2. Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ болон холбогдох бусад гэрээ, бичиг баримтад Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Таван Богд Холдингс ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал (Б.Оргил)-д олгосугай.
3. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн батлсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД: Д.ГЭРЭЛМАА

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998...2076357

Р.САРАНЦЭЦЭГ

Д.ХҮРЭЛБААТАР